



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 7 сарын 5 өдөр

Дугаар 359

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5,000,000.00 (таван сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож Орхон аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Х.Төгсбаяр, Орхон аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Т.Дэжидмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

132005232

18-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 4 дугаар сарын 6-ны өдрийн
49 дугаар тогтоолын хавсралт

ОРХОН АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ОРХОН АЙМАГ ДАХЬ ХАА-Н МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВД БАЛАНСААС
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоосон үнэ	Цаашид ашиглах хугацаа (жил)
			(төгрөг)		
1	Трактор FT-200 Хадуур тармуур иж бүрдэл	2014.04.02	5,000,000.00	300,000.00	3
Нийт дүн			5,000,000.00	300,000.00	-
Нийт дүн			(таван сая)	(гурван зуун мянган)	-